



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**Хэт богино долгионы радио өргөн
нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн
зурвасын хуваарилалт,
техникийн нөхцөл, шаардлага
танилцуулга**


Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар

2023.06.21



Радио долгионы тухай хууль

3.1.1. "радио долгион" гэж агаарын орон зайд тархаж байгаа цахилгаан соронзон орны 3000 гега герц хүртэлх давтамжтай хэсгийг;




4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн.



Олон улсын цахилгаан холбооны байгууллага

- 1865 онд үүсгэн байгуулагдсан
- 193 орон болон бизнес, эрдэм шинжилгээ, олон улсын, бүс нутгийн 900 орчим байгууллага гишүүнчлэлтэй
- Дэлхийн радио холбооны их хурлыг зохион байгуулдаг (1906 онд)




- Энэхүү хурлаар “Дэлхийн Радио холбооны Дүрэм”-д оруулах шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн баталдаг
- **Дэлхийн Радио холбооны Дүрэм** гэдэг нь радио давтамжийн спектр болон хиймэл дагуулын тойрог замыг дэлхий нийтээр ашиглах ашиглалтыг зохицуулах олон улсын гэрээ



РАДИО ДАВТАМЖИЙН БҮСЧЛЭЛ

*Радио
холбооны 42
үйлчилгээнд
радио
давтамж,
радио
давтамжийн
зурвасыг
хуваарилсан*





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ



- Харилцаа холбооны тухай хууль (2001)
- Радио долгионы тухай хууль (1999)
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)
- Зөвшөөрлийн тухай хууль (2022)



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

- Харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах
- Тусгай зөвшөөрөл олгох, түүнтэй холбоотой асуудлууд
- Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах, хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг тодорхойлох;
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ



- Харилцаа холбооны тухай хууль (2001)
- Радио долгионы тухай хууль (1999)
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)
- Зөвшөөрлийн тухай хууль (2022)



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

- Радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;



Монгол Улсын
Үндэсний радио
долгионы хүснэгт

1993

Монгол Улсын
Үндэсний радио
давтамжийн хүснэгт

1999

Үндэсний радио
давтамжийн
хуваарилалтын хүснэгт

2003

**Үндэсний радио
давтамжийн
хуваарилалтын
хүснэгт**

Үндэсний радио
давтамжийн зурвасын
төлөвлөлт

2013

Үндэсний радио
давтамжийн
хуваарилалтын хүснэгт

2016

Үндэсний радио
давтамжийн
хуваарилалтын хүснэгт

2020

**Үндэсний радио
давтамжийн
хуваарилалтын хүснэгт**

2023.05.09



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ РАДИО ДАВТАМЖИЙН ХУВААРИЛАЛТЫН ХҮСНЭГТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд заасан хүчин төгөлдөр эзэмшиж байгаа радио давтамж, радио давтамжийн зурвасын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссаны дараа сонгон шалгаруулалтын журмыг хэрэгжүүлсүгэй.
3. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг баримтлан радио давтамжийн зурвасын хуваарилалтыг шинэчлэн тогтоохыг Харилцаа холбооны зохицуулах хороо / Г.Чинзориг/-д зөвлөсүгэй.



75.2 – 137.175 МГц

Давтамжийн зурвас	ОУЦХБ-ын I бүсийн хуваарилалт	Үндэсний хуваарилалт	Ашиглалт	Тусгай нөхцөл
1	2	3	4	5
75.2-87.5 МГц	FIXED MOBILE except aeronautical mobile AERONAUTICAL RADIONAVIGATION 5.179 BROADCASTING 5.175 5.187	ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ-агаарын радионавигациас бусад АГААРЫН РАДИОНАВИГАЦИ 5.179 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ 5.175 (+MNG)	75.2-75.4 МГц давтамжийн зурвасыг агаарын радионавигацид ашиглана.	-
			76-87.5 МГц давтамжийн зурвасыг өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглана.	FM радиогийн өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах үйлчилгээнд сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
87.5 -100 МГц	BROADCASTING 5.190	ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлэгийн үйлчилгээнд ашиглана.	Сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
100-108 МГц	BROADCASTING 5.192 5.194	ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлэгийн үйлчилгээнд ашиглана.	Сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
108-117.975 МГц	AERONAUTICAL RADIONAVIGATION 5.197 5.197A	АГААРЫН РАДИОНАВИГАЦИ	Хэт богино долгионы давтамжинд ажиллах агаарын радионавигацийн тоног төхөөрөмжинд ашиглана.	-



ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

6 бүлэг, 29 заалт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 8 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

"ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА" ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ зүйлийн 5¹.1.2 дах заалтыг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

- 1."Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- 2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 12 тоот тогтоол, 2007 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 07 тоот тогтоол, 2012 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 14 тоот тогтоол, 2019 оны 04 сарын 29-ний өдрийн 15 тоот тогтоол, 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
- 3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.НАРАНМАНДАХ

Нэг. Нийтлэг үндэслэл
Хоёр. Холбогдох эрх зүйн баримт
бичиг
Гурав. Ерөнхий нөхцөл шаардлага
Дөрөв. Радио давтамжийн зурвасын
хуваарилалт
Тав. Хяналт
Зургаа. Бусад



“ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-ЫН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ТУХАЙ

📅 2023-05-29

АНГИЛАЛ

Бүгд

Онцлох

Гадаад хамтын ажиллагаа

Өргөн нэвтрүүлгийн
мониторингийн тайлан,
мэдээ

Радио, давтамжийн
хэмжилтийн тайлан, мэдээ

Ярилцлага

Сургалт, зөвлөгөөн

Хуралдааны тойм



FM төсөл 20230...

1 / 5



80%



“ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-ЫН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ТУХАЙ

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 тоот тушаалын хавсралтаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт” шинэчлэгдэн батлагдсан. Энэхүү хүснэгтээр хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн радио давтамжийн зурваст нэмэлт орсон тул Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал авч байна.

Та саналаа 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн дотор албан бичгээр ирүүлнэ үү. Нэмэлт тодруулгыг тус хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын ахлах



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичиг нь Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 51.1.2 заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлэгт /цаашид “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэг” гэх/ ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, техникийн нөхцөл шаардлагыг тогтооход оршино.

ХОЁР. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

- 2.1. Харилцаа холбооны тухай хууль;
- 2.2. Радио долгионы тухай хууль;
- 2.3. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль;
- 2.4. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт;
- 2.5. MNS 5591-1 : 2012 “Радиогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага”;
- 2.6. MNS 5591-2 : 2016 “Радиогийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага”;
- 2.7. MNS 4909 : 2000 “Алсын холбоо. Дуу, дүрс бичлэгийн техник. Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч. Техникийн шаардлага”;
- 2.8. MNS 5884 : 2020 “Холбооны цамхаг болон антены суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага”;
- 2.9. MNS 5594 : 2020 “Цахилгаан орон, соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (0 Гц - ээс 300 ГГц хүртэл)”;
- 2.10. MNS ISO/IEC 17020 : 2013 “Тохирлын үнэлгээ. Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага”;
- 2.11. “Зөвшөөрлийн тухай хууль” гэж нэмэлт оруулах.



ГУРАВ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 3.1. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үндсэн болон дахин дамжуулагч станц нь MNS 4909:2000 “Алсын холбоо. Дуу, дүрс бичлэгийн техник. Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч. Техникийн шаардлага” стандартын шаардлагыг хангасан тохирлын гэрчилгээ, техник хяналтын дүгнэлттэй байна.
- 3.2. Үндсэн болон дахин дамжуулагч станцын антен, фидерийн байгууламж нь MNS 5884:2020 “Холбооны цамхаг болон антены суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага” болон MNS 5594:2020 “Цахилгаан орон, соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (0Гц-ээс 300Гц хүртэл)” стандартуудыг хангаж ажиллана.
- 3.3. Радиогийн студи нь MNS 5591-1:2012 “Радиогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага”, MNS 5591-2:2016 “Радиогийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” стандартуудыг тус тус хангасан байна.
- 3.4. Радио давтамжийн харилцан нөлөөлөл, хажуугийн цацаргалт, интермодуляцаас сэргийлэх зорилгоор FM нэвтрүүлэгч антеныг бусад нэвтрүүлэгч антентай ижил түвшинд суурилуулахгүй. Хэрэв бусад антентай нэг цамхагт суурилах тохиолдолд антен хоорондын зай 2 метрээс багагүй байна.
- 3.5. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь радио нэвтрүүлэгч станц, антены цамхаг байгуулах газрын зөвшөөрөл болон бусад холбогдох зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байна.
- 3.6. Нэвтрүүлэгч станц болон антен фидерийн техник хяналтын дүгнэлтийг Зохицуулах хороогоор гаргуулж тохирлын гэрчилгээ авсан байна.



ГУРАВ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 3.1. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үндсэн болон дахин дамжуулагч станц нь MNS 4909:2000 “Алсын холбоо. Дуу, дүрс бичлэгийн техник. Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч. Техникийн шаардлага” стандартын шаардлагыг хангасан тохирлын гэрчилгээ, техник хяналтын дүгнэлттэй байна.
- 3.2. Үндсэн болон дахин дамжуулагч станцын антен, фидерийн байгууламж нь MNS 5884:2020 “Холбооны цамхаг болон антены суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага” болон MNS 5594:2020 “Цахилгаан орон, соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (0Гц-ээс 300Гц хүртэл)” стандартуудыг хангаж ажиллана.
- 3.3. Радиогийн студи нь MNS 5591-1:2012 “Радиогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага”, MNS 5591-2:2016 “Радиогийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” стандартуудыг тус тус хангасан байна.
- 3.4. Радио давтамжийн харилцан нөлөөлөл, хажуугийн цацаргалт, интермодуляцаас сэргийлэх зорилгоор FM нэвтрүүлэгч антеныг бусад нэвтрүүлэгч антентай ижил түвшинд суурилуулахгүй. Хэрэв бусад антентай нэг цамхагт суурилах тохиолдолд антен хоорондын зай 2 метрээс багагүй байна.
- 3.5. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь радио нэвтрүүлэгч станц, антены цамхаг байгуулах газрын зөвшөөрөл болон бусад холбогдох зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байна.
- 3.6. Нэвтрүүлэгч станц болон антен фидерийн техник хяналтын дүгнэлтийг Зохицуулах хороогоор гаргуулж тохирлын гэрчилгээ авсан байна.



ГУРАВ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

3.7. “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үндсэн сувгийг радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, дахин дамжуулагчийн сувгийг эрхийн бичиг авч ашиглана.” гэснийг “3.7. Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үндсэн сувгийг радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлөөр ашиглана. Үндсэн суваг эзэмшигч нь дахин дамжуулах сувгийг нэмэлтээр авч ашиглана.” гэж найруулах.

ДӨРӨВ. РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ

4.1. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлсон Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлгийн радио давтамжийн зурвасын хуваарилалт, ашиглалтыг хүснэгт 1-т үзүүлэв.



Давтамжийн зурвас	<u>ОУЦХБ</u> -ын I бүсийн хуваарилалт	Үндэсний хуваарилалт	Ашиглалт	Тусгай нөхцөл
1	2	3	4	5
75.2-87.5 МГц	FIXED MOBILE except aeronautical mobile AERONAUTICAL RADIONAVIGATION 5.179 BROADCASTING 5.175 5.187	ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ- агаарын <u>радионавигациас</u> бусад АГААРЫН <u>РАДИОНАВИГАЦИ</u> 5.179 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ 5.175 (+MNG)	75.2-75.4 МГц давтамжийн зурвасыг агаарын <u>радионавигацид</u> ашиглана. 76-87.5 МГц давтамжийн зурвасыг өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглана.	FM радиогийн өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах үйлчилгээнд сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
87.5 -100 МГц	BROADCASTING 5.190	ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглана.	Сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
100-108 МГц	BROADCASTING 5.192 5.194	ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	Хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглана.	Сонгон шалгаруулалтын журмаар олгоно.



4.2. Улаанбаатар хотод Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлэгт ашиглах үндсэн сувгийн хуваарилалтыг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Улаанбаатар хотод Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах үндсэн сувгийн хуваарилалт

Хамрах хүрээ	Зөөгч давтамж (МГц)					
	I	II	III	IV	V	VI
Улаанбаатар хот	88.3	91.7	95.7	98.9	101.7	104.5
	88.8	92.1	96.3	99.3	102.1	105.5
	89.3	92.5	96.9	99.7	102.5	106.0
	89.7	94.1	97.5	100.1	103.1	106.6
	90.5	94.5	98.1	100.5	103.6	107.0
	91.1	95.1	98.5	100.9	104.0	107.5



4.3. Орон нутагт Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлэгт ашиглах үндсэн сувгийн хуваарилалтыг хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Орон нутагт Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах үндсэн сувгийн хуваарилалт

Хамрах хүрээ	Зөөгч давтамж (МГц)				
	I	II	III	IV	V
Орон нутаг	87.5	89.1	97.9	101.9	
	87.9	89.9	98.7	102.7	105.9
	88.7	95.5	99.5	103.5	106.7
	89.5	96.3	100.3	104.3	107.5
	88.3	97.1	101.1	105.1	

4.3.1. Хүснэгт 3-т үзүүлсэн сувгийн зөөгч давтамж нь +/-100 кГц-ийн хооронд хэлбэлзэж болно.



ТАВ. ХЯНАЛТ

5.1. Энэхүү баримт бичгийн хэрэгжилтэд Харилцаа холбооны зохицуулах хороо болон харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Радио долгионы тухай хууль, Харилцаа холбооны тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллана.

5.2. Зохицуулах хороо нь энэ баримт бичгийн 3.1-ээс 3.4-т заасан шаардлагыг хангаж буй эсэхэд гомдол, хүсэлтийн дагуу болон 5 жил тутамд хяналт хийж, техник хяналтын дүгнэлт гаргана.

ЗУРГАА. БУСАД

6.1. Зохицуулах хороо нь энэ баримт бичигт заасан хууль тогтоомж болон өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний журам, нөхцөл шаардлага, техник технологийн дэвшил, үндэсний радио давтамжийн хуваарилалт, дахин төлөвлөлтөөс хамааруулан энэхүү баримт бичигт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

САНАЛ ӨГӨХ ТУХАЙ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

САНАЛ АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА: 2023 оны 6 сарын 29-ний өдөр



Радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглах
радио давтамжийн сонгон шалгаруулалтын зарчим



ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

5.6 дугаар зүйл. Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт



1. Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.15, 1.23, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18 дахь заалт, 5 дахь хэсгийн 5.1 дэх заалт, 8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх заалт, 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11 дэх заалт, 11 дэх хэсгийн 11.1, 11.9, 11.12 дахь заалт, 12 дахь хэсгийн 12.1, 12.2, 12.14 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2. Энэ зүйлийн 1-д заасан журмаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

9. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

9.8. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Радио долгионы тухай хууль:

5 дугаар зүйл. Радио долгионы талаар төрийн байгууллагын бүрэн эрх
5.2.6. үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах, хүснэгтэд
сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг тодорхойлох;

5'.1. Харилцаа холбооны зохицуулах хороо радио долгионы талаар дараах
бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5'.1.11. радио давтамжийн зурвасыг олгох сонгон шалгаруулалтыг зохион
байгуулах;



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



11 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох

11.4. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлсноос гадна ижил радио давтамжийг нэг нутаг дэвсгэрт ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгоно.

11.5. Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

11.6. Сонгон шалгаруулалтын үнэлгээнд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

11.6.1. радио давтамж ашиглан байгуулах сүлжээ, үйлчилгээний төрөл, түүний хамрах нутаг дэвсгэр;

11.6.2. техник, технологийн сонголт, үзүүлэлт;

11.6.3. үйлчилгээ хүргэх хугацааны төлөвлөлт;

11.6.4. өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө;

11.6.5. санхүүгийн төлөвлөлт, чадавх;

11.6.6. хүний нөөцийн чадавх;

11.6.7. тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага хангах байдал.



11.9.Энэ хуулийн 11.5-д заасан сонгон шалгаруулалтаар нэг этгээд хүсэлт ирүүлсэн бол тухайн этгээд хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд шалгарсан тухай мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулж, тусгай зөвшөөрлийг олгоно.

11.10.1.энэ хуулийн 11.5-д заасан хугацаанд хүсэлт ирүүлээгүй;

11.11.Энэ хуулийн 11.10.1-д заасны дагуу зарласан сонгон шалгаруулалтад сонирхогч этгээд хүсэлт ирүүлээгүй бол тухайн жилд дахин сонгон шалгаруулалт зарлахгүй.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА